



ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Баяжуулсан хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Албан журмаар баяжуулах хүнстэй ижил нэр төрлийн импортын бүтээгдэхүүн нь Монгол Улсын үндэсний стандартын шаардлагыг хангасан байна.” гэж заасан ба Засгийн газрын 2018 оны 336 дугаар тогтоолоор баталсан “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт”-д “буудайн гурил”-ыг тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан. Мал сүрэг нь Монгол Улсын үндэсний өвөрмөц, нөхөн сэргээгдэх баялаг, монголын соёл, уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв сан, тогтвортой хөгжлийн үндэс, эдийн засгийн тулгуурын нэг бөгөөд хүн амын амьжиргааны гол эх үүсвэр, хүнсний аюулгүй байдлын баталгаа, малчин өрхийн эдийн засгийн үндэс юм.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.10-т хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж заасан ба мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах нь хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол үйл ажиллагаа юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.7-д “Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.” гэж тусгасан.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй” гэж заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2.Практик шаардлага

Мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт:

Цаг агаарын нөхцөл байдлын талаар: Цаг уурын байгууллагаас 2024 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар гаргасан зудын үнэлгээгээр улсын хэмжээнд 6 аймгийн 23 суманд “төмөр буюу шилэн зуд”-ын, 17 аймгийн 88 суманд “цагаан зуд”-ын, 17 аймгийн 79 сум, нийслэлийн 2 дүүрэгт “цагаанаар зудархуу”, нийт 20 аймгийн 190 сум, нийслэлийн 2 дүүрэгт өвөлжилт хүндрэх нөхцөл бүрдээд байна.

Малын хорогдлын талаар: Улсын хэмжээнд 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 611,924 толгой мал хорогдсон бөгөөд Сүхбаатар /203,387/, Хэнтий /119,392/, Дорноговь /58,264/, Архангай /41,460/, Дорнод /36,066/, аймгууд хамгийн өндөр хорогдолтой байна. Оны эхний нийт малын тоотой харьцуулахад улсын дундаж 0.95%, Сүхбаатар аймаг 5.27%, Хэнтий 2.71%, Дорноговь аймаг 2.54%, буюу хэвийн хорогдлын хэмжээнээс давсан байна.

Өвс, тэжээлийн нөөцийн талаар: Аймаг, сумын аюулгүйн нөөцөд нийт 27.2 мянган тн өвс, 11.7 мянган тн тэжээл бэлтгэсэн. Үүнээс 2 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 12.3 мянган тн өвс, 6.1 мянган тн тэжээлийг зарцуулж, 15,3 мянган тн өвс, 5,7 мянган тн тэжээлийн үлдэгдэлтэй байна.

Отор нүүдлийн талаар: Улсын хэмжээнд өөрийн аймагт 5,117 өрхийн 2,128,381 толгой мал, өөр аймагт 2,765 өрхийн 1,194,260 толгой мал, өөр аймгаас 488 өрхийн 368,936 толгой мал, тусгай хамгаалалттай газарт 3,834 өрхийн 1,767,227 толгой мал, хилийн бүс орчимд 2,503 өрхийн 956,374 толгой мал, нийт 14,707 өрхийн 6,415,178 толгой мал отор, нүүдэл хийж байна.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Мөрөн, Улаан-Уул суманд, Увс аймгийн Тариалан суманд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд, Дорнод аймгийн Матад суманд нийт 4 аймгийн 6 суманд отрын штаб байгуулагдан ажиллаж байна.

Өвөлжилт хүндэрсэн малчин өрхийн талаар: Нийт 12 аймгийн 200 суманд зам, гарц хаагдсан 13,573 малчин өрх байгаа бөгөөд 38,444 км зам гаргах шаардлагатай байна.

Нийт 13 аймгийн 92 сумын 23,600 өрхөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүссэн, өвс, тэжээлийн хомсдолд орсон, түлээ түлш дууссан зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна.

Нийт 12 аймгийн 74 суманд үүрэн холбооны сүлжээгүй, холбоо тогтоож чадаагүй 3,137 малчин өрх байна.

Тэжээлийн импортын талаар: Монгол Улсын хилээр 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийн хооронд нийт 1,555,172 тн хивэг импортолсон байна.

Нийт 18 аймгийн 172 суманд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөц дуусаж байгаа бөгөөд, зам даваа хаагдсан, туулах чадвар сайтай автомашин, шатахуун, хүнс, ялангуяа гурилын хангалт шаардлагатай нөхцөл байдалтай үүсээд байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг эрсдэл багатай даван туулахад шаардлагатай нийт тэжээлийн 55 орчим хувийг дотооддоо үйлдвэрлэн нийлүүлж, үлдсэн хэсгийг импортоор авдаг.

Нийт нутгийн 80 гаруй хувьд нь цасан бүрхүүл тогтож ихэнх нутгаар хүйтний эрч чангарч, мал аж ахуйн салбарын хаваржилт хүндэрч, мал сүрэг өвс тэжээлийн дутагдалд орж, малчид ихээхэн хохирол амсах эрсдэл үүсээд байна.

Хаваржилтыг хохирол багатай даван туулахад малын өвс, тэжээлийн нөөц хангамжийг нэмэгдүүлэхэд 100-200 мян.тн өвс, 385-412 мян.тн нэмэгдэл тэжээл шаардлагатай байгаа бөгөөд үүний 70-80 хувийг импортлон авах нөхцөл үүсээд байна.

Иймд орон нутагт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, доройтож тэжээлийн дутагдалд орсон малыг хурдан тэнхрүүлэхэд өвс, хивэг, овъёос, арвай, хөх тариа, эрдэнэшиш, багсармал хорголжин тэжээл, гахай, шувууны тэжээл, тэжээлийн нэмэлт болох эрдэс, уургийн нэмэгдлүүдийг импортлоход гаалийн албан татварыг чөлөөлөх шаардлагатай байна.

Амьтны гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн тэжээл болон гэрийн тэжээвэр амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт нь энэ хуулийн төслийн үйлчлэлд хамаарахгүй.

Гурил:

Хүнсний тухай хуулийн 3.1.6-д заасны дагуу улаанбуудайн гурил нь монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай стратегийн хүнсний нэг юм.

Хүнсний бүтээгдэхүүний хоногт эзлэх хэмжээг тодорхойлсон судалгааны дүнгээр хоногийн хэрэглээний 63 хувийг үр тариа, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болох гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна. Дэлхий нийтийг хамарсан өвчин, геополитикийн нөхцөл байдал, дотоодын ургацын улаанбуудайн чанар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өргөн хэрэглээний 1 дүгээр гурилын үнэ сүүлийн 2 жилийн хугацаанд 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 дугаар судалгаанд ихэнх айл өрх буудайн гурилыг өдөр тутам хэрэглэдэг тул гурилыг В, Д аминдэм болон төмөр, фолийн хүчлээр баяжуулж хэрэглэх нь эрүүл мэндийг дэмжих ач холбогдолтой талаар зөвлөмж болгосны дагуу Баяжуулсан хүнсний тухай хуулийг баталж, дээд болон 1 дүгээр ангиллын гурилыг баяжуулан хэрэглэх шаардлага тавьсан.

Монгол Улсын нийт өрхийн 32 хувь нь хөдөөд амьдарч байгаа ба үүнээс 81.5 хувь малчин болон малтай өрх байна.

Хөдөөгийн хүн амын дунд мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ нь бусад төрлийн хүнстэй харьцуулахад өндөр бөгөөд уламжлалт хүнс нь байдаг. Улирлын онцлогоос хамаарч сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамж дутмаг байгаагийн зэрэгцээ өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, зам даваа хаагдсаны улмаас хүнсний тээвэрлэлт доголдож байгаа одоогийн нөхцөлд гурил, гурилан бүтээгдэхүүний хангамж, хүртээмжийг тасалдуудахгүй байх, үнийн өсөлтөөс сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Манай улсын жишсэн хүн амын гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг 2024 оны байдлаар тооцоход 290.9 мянган тонн байна.

Гурил, гурилан бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, нөөцийг харгалзан жилийн нийт хэрэгцээний 10 хүртэл хувь буюу 25.0 мян.тн улаанбуудайн гурилыг Монгол Улсын хилийн боомт бүхий аймгуудаар импортлох шаардлага үүсээд байна.

Иймд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон 25 000 тонн баяжуулсан гурилыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд импортлоход гаалийн албан татвараас чөлөөлөх саналыг боловсрууллаа.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг гурван зүйлтэй байхаар боловсруулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, 25 000 тонн баяжуулсан гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2 дугаар зүйлд Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, баяжуулсан гурилын жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” /БТКУС/-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батлахаар, 3 дугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав. Гурав.Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засгийн үр дагавар, гарах үр дүн

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна.

1. Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давах нөхцөл боломж, бүрдэнэ.

2. Хуулийн үйлчлэх хугацаанд хүнсний үйлдвэрлэлийн тэр дундаа гурил, гурилан бүтээгдэхүүний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хадгалж, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хууль гарсантай холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд төсөл батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах хууль байхгүй.

-----oOo-----